



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/262

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” -ын 2.4.6.6, Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 6.1.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2014 6.1-д зааснаар эмийн жорын хяналтыг сайжруулах, жор бичилтийг бүртгэх, жорын дагуу эм худалдан авах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “Цахимаар эмийн жор бичих, олгох заавар”-ыг хавсралтаар баталсугай .
2. Цахимаар жор бичих, олгох үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Э.Содномжамц) – д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081106

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 06 сарын 29 өдрийн
А/262 дугаар тушаалын хавсралт



ЦАХИМААР ЭМИЙН ЖОР БИЧИХ, ОЛГОХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү зааврыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага, эмийн сан цахимаар эмийн жор бичих, олгоход мөрдөнө.

Хоёр. Цахим жор ба түүний баталгаажилт

- 2.1. Энэ зааварт хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1. "Цахим жор" гэж "Эмийн жорын маягт, жор бичилт" MNS 5376:2014 стандартын 4.1 дүгээр заалтад заасан эмийн жорыг цахим хэлбэрээр дамжуулж буй хэлбэрийг;
 - 2.1.2. "Цахим жорын систем" гэж эмийн жорын мэдээллийг цахим хэлбэрээр үүсгэх, хадгалах зориулалт бүхий Үндэсний Дата Төв дээр байрлах жорын бүртгэл, хяналтын цахим системийг;
 - 2.1.3. "Хяналтын дугаар" гэдэг нь тухайн эмийн жор бүрд цахим жорын системээс олгогдох 6 орон бүхий ялгаатай дугаарлалтыг.
- 2.2. Цахим жорын системээр үүсгэсэн эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жорын хяналтын дугаар нь гурван сарын хугацаанд дахин давтагдахгүй.
- 2.3. Цахим жорын системээр үүсгэсэн эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгогдохгүй эмийн жор нь зургаан тэг /000000/ бүхий хяналтын дугаартай байна.

Гурав. Цахим хэлбэрээр жор бичих

- 3.1. Эмч цахим жор бичихдээ "Эмийн жорын маягт, жор бичилт" MNS 5376:2014 стандартыг баримтална.
- 3.2. Цахим жор бичихэд эмч өөрийг нь төлөөлөх шифрийн дугаараар жорын системд нэвтэрч жор бичнэ.
- 3.3. Цахим жорын системд эмч иргэний бүртгэлийг иргэний үнэмлэхээр баталгаажуулан регистрийн дугаараар бүртгэх ба үзлэгийн тэмдэглэлийг бичиж оруулан, оношийг олон улсын өвчний 10 дугаар ангилалын кодоор тавьж, системээс эмийн олон улсын нэршил, тун хэмжээг сонгож тоо ширхэгийг бичнэ.
- 3.4. Системээс сонгосон эмийн хэрэглэх арга, эмчилгээний үргэлжлэх хугацааг "Тэмдэглэл" хэсэгт бичнэ.
- 3.5. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг цахим жорын системд бүртгэж, энэхүү зааврын 2.1.1 дэх хэсэгт заасан стандартын дагуу мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягыг ашиглан бичиж, хяналтын дугаарыг жорын доод хэсэгт эмчийн гарын үсгийн дээд талд бичнэ.
- 3.6. Цахим хэлбэрээр бичсэн энгийн эмийн жорыг иргэний хүсэлтийн дагуу жорын маягт дээр бичиж өгч болох ба хяналтын дугаарыг жорын доод хэсэгт эмчийн гарын үсгийн дээд талд бичнэ.

- 3.7 Цахим жорын хяналтын дугаарыг амбулаториор үйлчлүүлэгчдийн картанд тухайн өдрийн үзлэгийн тэмдэглэл хэсэгт эмийг олон улсын нэршил, тун хэлбэр, хэрэглэх зааврын хамт бичнэ.
- 3.8 Цахим жор бичигдсэн өдрөөс хойш долоо хүртэлх хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Дөрөв. Цахим жороор үйлчлэх

- 4.1. Эмийн сан цахим жороор үйлчлэхдээ Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартыг баримтална.
- 4.2. Эмийн сангийн жор баригч иргэний амбулаториор үйлчлүүлэгчдийн карт дахь хяналтын дугаарыг системд оруулж иргэний үнэмлэхтэй тулган баталгаажуулна.
- 4.3. Цахим жороор иргэнд эмийг олгохдоо эмийн нэр, тун хэлбэр, тоо хэмжээг цахим жорын системийн мэдээллийн дагуу олгоно.
- 4.4. Цахим жорын хяналтын дугаар нь гурав хүртэл эмийн санд дараалан ашиглагдах боломжтой байна.
- 4.5. Эмийн санд Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгогдох эмийг борлуулсны дараа эмийн худалдааны нэршил, бар код, тоо ширхэг, хяналтын дугаар болон Татварын Ерөнхий Газраас үүссэн ДДТД /дахин давтагдашгүй төлбөрийн дугаар/-ыг цахим жорын системд илгээнэ.

Тав. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг

- 5.1. Цахим жорын системийн тогтвортой үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангана.
- 5.2. Цахим жорын систем ашиглах арга зүйгээр эрүүл мэндийн салбарын байгууллагуудыг хангана.
- 5.3. Цахим жорын системээс эмийн бүртгэл, статистикийн үзүүлэлтийг гаргана.

Зургаа. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үүрэг

- 6.1. Цахим жороор бичигдсэн эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтаар батлагдсан эм түүнтэй холбоотой эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтийг тооцон санхүүжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллана.
- 6.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалт шинэчлэн батлагдах тухай бүрд эмийн нэр, үнэ, хөнгөлөлтийн хувь хэмжээг цахим жорын системд оруулна.

Долоо. Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын үүрэг

- 7.1. Цахим жорын систем хэрэглэх талаарх сургалт зохион байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.
- 7.2. Цахим жорын системд нэвтрэх эм бичих эрх бүхий эмчийн шифрийн дугаар, эрхийг үүсгэж, хяналт тавина.
- 7.3. Бүх шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, эмийн санг цахим жорын системд хамруулах, хамрагдалтын тайланг Эрүүл Мэндийн хөгжлийн төвд хагас жил тутамд хүргүүлнэ.